



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2020 оны 12 сарын 17 өдөр

Дугаар

A/805

Ховд

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.2-ийн "б", Барилгын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.6, Засгийн газрын 2018 оны 317 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан барилга байгууламжийг ашиглалтад оруулах дүрмийн 3.1.2, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 78 дугаар зүйлийн 78.2.4, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2017 оны 87 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. "Уян дөш" ХХК-ийн хийж гүйцэтгэсэн Жаргалант сумын Бичигт багт жишиг гудамж тохижуулах ажлыг хүлээн авах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч:

Э.Дөлбадрал

-Газрын харилцаа барилга хот байгуулалтын газрын дарга

Гишүүд:

Д.Нямтулга

- Мэргэжлийн хяналтын газрын Барилгын техникийн хяналтын Улсын байцаагч

Д.Эрдэнэбат

- Аймгийн Засаг даргын Тамгын газрын дэд бүтэц хариуцсан гэрээт ажилтан

Д.Ариунболд

-Жаргалант сумын Хотын захирагчийн ажлын албаны мэргэжилтэн

С.Бат-Эрдэнэ

-Жаргалант сумын Бичигт багийн Засаг дарга

Ц.Даваасамбуу

-Орон нутгийн өмчийн газрын ахлах мэргэжилтэн

С.Батдорж

-Аймгийн архивын тасгийн дарга

П.Эрдэнэбаатар

- "Уян дөш" ХХК-ийн захирал


Нарийн бичгийн
дарга:

Д.Тогтохбаяр

-Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын
газрын Барилга хот байгуулалтын
хэлтсийн ахлах мэргэжилтэн

2. “Уян дөш” ХХК-ийн хийж гүйцэтгэсэн ажлыг захиалагчаас өгөгдсөн ажлын тоо хэмжээтэй тулган, шалгаж өмч бүртгэлд тусгаж хүлээн авах эсэх талаар шийдвэр гарган танилцуулахыг ажлын хэсгийн ахлагч /Э.Дөлбадрал/-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГЫН
ОРЛОГЧ



Т.ЖАРГАЛСАЙХАН